



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/41

Өвт

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын төвийн гэрэлтүүлгийн урсгал засварын зардалд 6,500,000 (зургаан сая таван зуун мянган) төгрөг, нохой устгалын зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг, нийт 9,500,000 (есөн сая таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас, 6,500,000 (зургаан сая таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын урсгал засварын зардлаас тус тус зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ